



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/56/

Эрдэнэт


Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5./а/, 29.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10.1.2, 10.1.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Заан цолтонд хүндэтгэл үзүүлэх 11 дэх удаагийн үндэсний бөхийн барилдаан 2017 оны 09 дүгээр сарын 23, 24-ний өдрүүдэд Орхон аймагт зохиогдох гэж байгаатай холбогдуулан санхүүгийн дэмжлэг үзүүлж шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Дэмжлэгт шаардагдах 4670500 /Дөрвөн сая зургаан зуун далан мянга таван зуун/ төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
09 дүгээр сарын 22-ны өдрийн
А/Б/С... дугаар захирамжийн хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ЗААН ЦОЛТОЙ БӨХЧҮҮДЭД
ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ БӨХИЙН
БАРИЛДААНЫ ТӨСӨВ**

№	Хийгдэх ажил	Нэг бүрийн үнэ	Тоо хэмжээ	Мөнгөн дүн
1	Засаг даргын хүлээн авалт	50000	50	2500000
2.	Засаг даргын гарын бэлэг	43000	38	1634000
3.	Монгол улсын Заан цолтнуудын тухай номын зохиогч Түвдэнгийн Сэр-Од, Монгол улсын Заан цолтнуудын тухай дууны аяыг зохиогч Чойжинжавын Өнөрбат нарт хүндэтгэл үзүүлэх	43000	2 хүн	86000
4.	Анонс /1м2/	600	6х4=24м	144000
5.	Урилга	1500	80ш	120000
6.	Ул боов	2500	25ш	62500
7.	Ааруул	12000	2кг	24000
8.	Нээлтийн арга хэмжээний зардал			100000
	Төсвийн нийт дүн			4670500